



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 12 сарын 15 өдөр

Дугаар А/613

Улаанбаатар хот

"Үндэсний цэцэрлэгт хүрээлэн" ОНӨТҮГ-ын данс бүртгэлд хөрөнгө бүртгэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийн 4 дэх заалт болон 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан "Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам"-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 3 дугаар зүйлийн 3.2.3 дахь заалт, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны А/481 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан "Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс"-ын 2024 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 12 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1."Улаанбаатар хотын хүнсний хог хаягдал дахин боловсруулах төсөл"-ийн хөрөнгөөр нийлүүлсэн нийт 33,543,659.80 (гучин гурван сая таван зуун дөчин гурван мянга зургаан зуун тавин есөн төгрөг наян мөнгө) төгрөгийн үнэ бүхий хавсралтад заасан эргэлтийн бус хөрөнгийг данс бүртгэлдээ бүртгэн авахыг "Үндэсний цэцэрлэгт хүрээлэн" ОНӨТҮГ (Ё.Нямжав)-т зөвшөөрсүгэй.

2.Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг "Үндэсний цэцэрлэгт хүрээлэн" ОНӨТҮГ (Ё.Нямжав)-т үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, шалгалтын хэлтэс (Г.Тэмүүжин)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



В.ОЮУМАА

Нийслэлийн Өмчийн харилцаа
эргэн 2024 оны 12 дугаар сарын
өдрийн 16/12 дугаар тушаалын

Байгууллагын нэр: "Үндэсний цэцэрлэгт хуээлэн" ОНӨТҮГ

Нийт бүртгэх хөрөнгийн дүн